

## Улаанбаатар хотод төмөр зам дээгүүр гүүрэн гарц барих төсөл (Буцалтгүй тусламж)

### Үндэслэл

Улаанбаатар хотын зам тээврийн босоо тэнхлэгт төмөр замын хоёр гарам, хоёр гүүр (Гурвалжингийн гүүр: 1987 онд баригдсан, 4 эгнээтэй, 108 метр урт, Энхтайваны гүүр: 1961 онд баригдсан, 4 эгнээтэй, 340 метр урт) байдаг ба эдгээр гүүрүүд нь элэгдэл хуучрал, эвдрэл зэргийн улмаас тээврийн аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тухай асуудал хөндөгдөж ирсэн.

1999 онд Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу JICA “Улаанбаатар хотын авто зам төлөвлөлтийн судалгаа”-г хэрэгжүүлж, хотын зам тээврийн нөхцөл байдлыг сайжруулах мастер төлөвлөгөөг боловсруулсан. Уг судалгааг хэрэгжүүлснээр авто замын сүлжээг эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаанд хамгийн үр өгөөжтэй байдлаар хөгжүүлэхэд одоо байгаа хоёр

гүүрээс гадна Улаанбаатар хотын төв тойрог зам (Middle Ring Road)-ын бүрэлдэхүүн хэсэг болгож төмөр зам дээгүүр давсан шинэ гүүр барих шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Гэвч Монгол талын хувьд технологийн болон санхүүгийн дутмаг байдлаас үүдэн дан өөрийн хөрөнгөөр дээрх ажлыг гүйцэтгэхэд ихээхэн хүндрэлтэй байсан тул 2005 оны 6 дугаар сард Япон улсын Засгийн газарт хандан тус гүүрийг буцалтгүй тусламжийн шугамаар барьж гүйцэтгэх хүсэлтийг гаргасан. Улмаар Японы Засгийн газар 2009 оны 5 дугаар сард нийт 3.7 тэрбум иений буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж, гүүрийн угсралтын ажил 2009 оны 5 дугаар сараас эхлэн 3 жил 6 сарын төлөвлөгөөтэй явагдаж эхэлсэн.

### Агуулга

Их тойруугийн өргөн чөлөө болон Энгельсийн өргөн чөлөөг холбосон төмөр замын гүүрэн гарц байгуулах (Гүүрийн урт 262 м, нийт замын урт 633 м)



Гүүрний харагдах байдал



Япон мэргэжилтнээр ахлуулсан технологийн сургалт

### Үр дүн

Угсралтын ажлыг гүйцэтгэсэн Япон болон Монголын барилга угсралтын компаниуд, мөн төслийн холбогдох хүмүүсийн хүчин чармайлтын үр дүнд Монгол улсын анхны металл хийцийн гүүр 2012 оны 10-р сард баригдаж дуусав. Ингэснээр Улаанбаатар хотод сайн чанарын, найдвартай гүүрэн гарц бий болж тээврийн хэрэгслүүд төмөр замын гармаар гаралгүйгээр урд хойд зүгт аюулгүй, чөлөөтэй зорчих боломжтой болж буй юм. Мөн

Энхтайваны өргөн чөлөөнөөс Чингисийн өргөн чөлөө хүртэлх 4.7 километр зай 1.8 километр болон товчлогдож, урд хойд зүгт чиглэсэн хөдөлгөөн чөлөөтэй явагдсанаар хотын бүсийн хөдөлгөөний орчин сайжирч, эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжих, нийгмийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх нөхцлийг бүрдүүлэх ба үүний үр шимийг Улаанбаатар хотын 1,200,000 (2011 оны статистик) иргэн шууд хүртэх юм.